

Тохирогч нөгөө Этгээдийн эрх бүхий байгууллага нутаг дэвсгэрт нь асруулан хамгаалуулагч, харгалзан дэмжуулэгчийн байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн байгууллагад асран хамгаалуулах, харгалзан дэмжуулэх тухай хэргийг шилжуулж болно. Асран хамгаалах, харгалзан дэмжих тухай шилжуулсэн хэргийг хулээн авагч байгууллага асран хамгаалуулах, харгалзак дэмжуулэх тухай хэргийг хулээн авснаа кусэлт ируулсэн байгууллагад мэдэгдсэнээс хойш хучин тогөлдөр болно.

2. Энэ зуйлийн I дэх ангид зааснаар асран хамгаалуулах, харгалзан дэмжуулэх тухай хэргийг хулээн авсан 'Хэлэлцэн Тохирогч Этгээдийн байгууллага уг хэргийг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Энэ байгууллага асруулагчийн хувийн зрхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргаж болохгүй.

4. Өв залгамжлах т.ухай

Дочин гуравдугаар зуйл

Тэгш эрхийн зарчим

1. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн харьяат Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө, эрхийг хууль есөөр болон гэрээслэлээр өвлөн авахдаа тэрхуу Хэлэлцэн Тохирогч Этгээдийн харьяатын адил нөхцөл, хэмжээгээр эдэлнэ.

2. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн харьяат Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт оайгаа өөрийн эд хэрөнгийг гэрээслэлпйн дагуу захиран зар* уулж болно.

До чин дорөвдүгээр зуйл

Өв залгамжлалын талаар хэрэглэх хууль тогтооиж

I, Ходлөх эд хоронгийг өвлөх эрх нь л залгамжлуулагч нас барах уедоо харьяат кь байсан Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хууль тогтоомжоор зохинуулагдана.